



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийг судлах музейн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/28/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
	Аудитор: С.Санчирмаа
	Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 25 № 100

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийтийн номын сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Говь-Алтай аймгийн Орон нутгийг судлах музейн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар санхүүгийн тайланг зөрүүтэй тайлагнасан, харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, хөрөнгийг орлого аваагүй, капиталжуулаагүй, шууд зардлаар тайлагнаж, анхан шатны зарцуулалтын баримтгүй ажил гүйлгээг бүртгэсэн, нярвын тайлан гараагүй, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, томилолтын мөнгийг илтгэх хуудасгүй, томилолтын хуудасгүй олгосон, эдийн засгийн ангилал зөрчсөн, цалингийн зардлын төсвөөс шагнал олгосон, тушаал, шийдвэргүй ээлжийн амралт олгосон, гэрээний заалт зөрчин ажил гүйцэтгээгүй байхад хөлсийг шилжүүлсэн, албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан олгосон, албан хаагчийн цалинг албан тушаалын тодорхойлолтоос, захирлын цалингийн сүлжээ шатлалыг тус тус зөрүүтэй тогтоосон зэрэг 13,632.8 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.4, 16.5.5, 22.1, 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 57.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3 заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,880,080.6 мянган төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хүлээн авч, бүртгэсэн байна. Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 53,843.3 мянган төгрөгөөр буурсан байна

Аудитын гол асуудал

0702900269

Няравын тайлан гаргадаггүй, жилийн эцэст хөрөнгийн тооллогыг хийгээгүй, нягтлан бодох бүртгэлийг стандарт, зааврын дагуу хөтлөөгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 зорилт 16 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 14 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 80.0 хувь, 1 арга хэмжээ 70.0 хувь буюу нийт дүнгээр 97.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн боловч ажлын дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	49,769.1	42,685.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,163,575.3	5,025,605.2
	Нийт хөрөнгийн дүн	1,213,344.5	5,068,290.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,374.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,213,344.5	5,066,916.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,213,344.5	5,068,290.3
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,453,285.4	4,261,750.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	325,182.2	451,800.3
	Үйл ажиллагааны үр дүн	1,128,103.2	3,809,949.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,128,103.2	3,853,571.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121.3	1,213,344.5
	НББ-ийн өөрчлөлт	-	(1,130,383.2)
	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	85,120.0	1,130,383.2
	Тайлант оны үр дүн	1,128,103.2	3,853,571.7
	Эцсийн үлдэгдэл	1,213,344.5	5,066,916.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	333,100.0	313,378.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	309,184.5	319,462.9
	Үйл ажиллагааны ЦМГ	23,915.5	(6,084.0)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(1,000.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	23,915.5	(7,084.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,915.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,915.5	16,831.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	323,052.4	313,941.5
	Урсгал зардал	323,052.4	313,941.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	323,052.4	313,083.9
	Улсын төсвөөс санхүүжих	291,557.4	202,223.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	109,522.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаа	31,495.0	1,338.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	23,915.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,516.5

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 4,258.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн хөрөнгийн тайланд 4,258.6 мянган төгрөгийн эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 281,275.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их бөгөөд илэрсэн алдаа зөрчил нь санхүүгийн тайлангийн бүх данстуудад өргөн тархсан материаллаг зөрчил илэрсэн тул "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 281,275.1 мянган төгрөгийн 17 зөрчил² илэрснээс, 1 төлбөрийн акт, 13 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдад 2,150.4 мянган төгрөгийн шагнал урамшууллыг цалингийн зардлаас давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг 9,361.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд 36 харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, авлага, өглөгийн үлдэгдлийг бүрэн баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага хүргүүлсэн.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Үзмэрийн ном 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан боловч орлого аваагүй, шууд зардлаар тайлагнасан, зарцуулалтын баримтгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу дагаж мөрдөх албан шаардлага хүргүүлсэн.

4. Хантайшир уулын аймаг байгуулагдсны 100 жилийн арга хэмжээнд ашигласан 350.0 мянган төгрөгийн үзмэрийн гэрлийг шууд зардлаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шууд зардлаар тайлагнасан бараа материалыг орлогод бүртгэж, хөрөнгөнд хяналт тавих албан шаардлага хүргүүлсэн.

5. Тайлант онд няравын тайланг огт гаргаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн дагуу няравын тайланг үнэн зөв хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

6. Урсгал засвар хийсэн 13,430.0 мянган төгрөгөөр хөрөнгийг капиталжуулж орлого аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урсгал засварыг нягтлан бодох бүртгэлийн дагуу капиталжуулж бүртгэх албан шаардлага хүргүүлсэн.

7. Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн арга хэмжээтэй холбоотойгоор ном хийсэн ажилтанд ажлын тайланг үндэслэж, томилолтын илтгэх хуудас, томилолтын бичиггүй 3,500.0 мянган төгрөгийн томилолтыг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно" Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гүйлгээ хийхгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

8. Цалингийн сангаас 2 албан хаагчид 750.0 мянган төгрөгийн шагналт цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

9. Орон нутгийн судлах музейн арга зүйч эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр ээлжийн амралтыг эдэлж, 2,413.5 мянган төгрөгийн амралтын мөнгө олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэрээр ээлжийн амралтыг олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

10. Ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргийг хэрэгжүүлсэн албан хаагчид ажил хавсран ажилласны нэмэгдэл 2,700.3 мянган төгрөгийн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах"; 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр нэмэгдэл олгож буй зөрчлийг арилгаж байх албан шаардлага хүргүүлсэн.

11. Тайлант онд захирлын цалингийн сүлжээ шатлалыг зөрүүтэй тогтоож 670.8 мянган төгрөгийн, албан тушаалын тодорхойлолтоос зөрүүтэй 3,049.7 мянган төгрөгийн цалин илүү

олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн сүлжээ шатлалыг хууль, журмын дагуу үнэн зөв тогтоох албан шаардлага хүргүүлсэн.

12. Даатгуулагчаас төлөх 2,966.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

13. Мастер Күалити ХХК-тай байгуулсан гэрээний заалтыг зөрчин ажил гүйцэтгэж дуусаагүй байхад 4,301.2 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгүүлж, санхүүжилтийг олгож байх албан шаардлага хүргүүлсэн.

14. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгээгүй, тооцоо бодоогүй, эд хариуцагчаар баталгаажуулаагүй, бараа материалыг тоолоогүй нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалын үүргээ хэрэгжүүлээгүй нягтлан бодогч, нярав нарт сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг шалгуурын дагуу дүгнээгүй, сар бүр хавтгайруулан 5,720.5 мянган төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаал "төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан 1996 оны 04 сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаал "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ын 5-д "ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна", 7-д "7.Ур чадварын нэмэгдлийг ажилтнуудын цалинг нэмэх, амьдрал ахуйг харгалзах зэргээр хавтгайруулан олгохыг хориглоно."-тай нийцэхгүй байна.

нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварыг нэмэгдлийг олгохдоо улирал бүр шалгуурын дагуу дүгнэж олгох

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бүрэн дуулга ХХК-д олгосон 21,450.0 мянган төгрөгийн гэрээт харуулын хөлсийг цалингийн зардлын төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтын 210303-т "Цэвэр бохир усны зардалд зөвхөн байгууллагын дотоод хэрэгцээнд хэрэглэхээр төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамж ашиглах цэвэр ус төвлөрсөн ариутгах татуургын системээр болон тусгай үйлчилгээгээр соруулж зөөвөрлөсөн бохир усны зардал хамаарна" нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгуулла- гын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагү й			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутгийг судлах музей	1	4.2	-	-	1	4.2	1	4.2	-	-	-	-
Дүн	1	4.2	-	-	1	4.2	1	4.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орон нутгийг судлах музей	17	281.3	1	2.1	14	257.7	2	21.5	-	-	-	-
Дүн	17	281.3	1	2.1	14	257.7	2	21.5	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	--------------------------	-------------------------

	Төсвийн захирагчийн ангилал	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1					1	
	НИЙТ		1					1	